

## **ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНД ОРОХ ИРГЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРМЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2020.09.03

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 47 дугаар зүйлийн 47.9 дэх хэсгийн дагуу “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ыг Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар баталсан нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсгийг 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан ба өөрчлөн найруулсан зохицуулалтын дагуу шинээр батлагдах журам нь үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаанд мөн хамааралтай байх тул хуулийн дээрх хоёр эрх олгосон заалтаар батлах журмуудын зохицуулах харилцааг нэгтгэн “Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн сангийн болон үнэлгээний хорооны ажиллах журам”-ын төслийг боловсрууллаа.

Энэхүү журмын төслийг боловсруулахдаа худалдан авах ажиллагаатай холбоотой дүрэм, журмыг шинэчлэх талаар саналаа ирүүлэхийг хүссэн Сангийн сайдын сайдын 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 6-1/7062 дугаар албан бичгийн хариуд захиалагч байгууллагуудаас ирүүлсэн саналыг тусгасан болно.

Тус журмын хүрээнд бий болох “үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн сан” нь холбогдох журмын дагуу худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээ авсан иргэдийн мэдээллийг нэгтгэсэн байхаар зохицуулсан ба Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тус мэдээллийн сангийн мэдээллийг тогтмол шинэчлэхээр журамласан.

Үнэлгээний хорооны бүтэц, зохион байгуулалт, урамшууллын харилцааны тухайд үнэлгээний хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх үндэслэл, журмыг тодорхой болгох, үнэлгээний хорооны гишүүн ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдүүлгээ холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэдүүлж байх, тендерийн баримт бичгийг боловсруулахдаа ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зэрэг асуудлаар шинэчилсэн зохицуулалтыг боловсруулсан.

-оОо-

## **ТЕНДЕР ҮНЭЛЭХ, ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИДОД ДАВУУ ЭРХ ОЛГОХ АРГАЧЛАЛ, ЗААВРЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2020.09.03

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийн дагуу Сангийн сайдын 2018 оны 58 дугаар тушаалаар “Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал”-ыг, 28 дугаар зүйлийн 28.16 дахь хэсгийн дагуу Сангийн сайдын 2008 оны 249 дүгээр тушаалын хавсралтаар “Зөвлөх үйлчилгээний тендерийн үнэлгээний заавар (жишиг маягтууд)”-ыг, 2012 оны 194 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар “Тендерийн үнэлгээний заавар (маягтууд)”-ыг тус тус баталсан нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Захиалагч нь тендер хянан үзэх, үнэлэхдээ дээр дурдсан аргачлал, заавруудыг дагаж мөрдөх ёстой боловч тус тусдаа батлагдсан эдгээр баримт бичиг, түүний маягтууд нь хэрэглэхэд хүндрэлтэй, өөр хоорондоо зөрчилдөөнтэй байгаагийн улмаас захиалагч, түүний байгуулсан үнэлгээний хороо нь тендерийг үнэлж, “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг шалгаруулахад алдаа дутагдал гаргах явдал түгээмэл байна.

Түүнчлэн одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тендер үнэлэх аргачлалын зохицуулалт нь тендерийн жишиг баримт бичгийн зохицуулалтыг дахин давтан зохицуулсан шинжтэй ба тендер үнэлэхтэй холбоотой захиалагчид түгээмэл тулгамддаг зарим асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөн туслах шинжтэй зохицуулалтыг аргачлал, зааварт тусгах хэрэгцээ шаардлага бий болоод байна.

Иймд хуулиар тендер үнэлэхтэй холбоотой аргачлал, заавар батлах эрх олгосон дээрх зохицуулалтын дагуу батлах “Тендер үнэлэх, тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал, заавар”-ын төслийг боловсрууллаа.

Тус аргачлал, зааврын төсөл нь бараа, ажил, үйлчилгээ (үүний дотор зөвлөх үйлчилгээ) гүйцэтгэх тендерийг үнэлэхтэй холбоотой захиалагчийн анхаарвал зохих асуудлыг нэгтгэж, түүнд хэрэглэх маягтуудыг нэгтгэснээрээ онцлог юм.

Түүнчлэн уг аргачлал, зааварт тендер хянан үзэж, үнэлсний үндсэн дээр тендерт оролцогчид хүргүүлэх мэдэгдлийн жишиг маягтыг боловсруулан оруулсан нь хуулийг хэрэгжүүлж буй захиалагч байгууллагууд нь хуулийг нэг мөр ойлгож, мэдэгдэл хүргүүлэх ажиллагаанд алдаа дутагдал гаргахгүй байхад ач холбогдолтой гэж үзнэ байна.